



## “УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ” ХХК

Улаанбаатар аудит корпораци нь хараат бус аудит, баталгаажуулалт, татварын болон зөвлөх үйлчилгээний дэлхийд тэргүүлэгч байгууллагуудын нэг Грант Торитон Интернэйшнлийн Монгол улс дахь Корреспондент гишүүн (www.gti.org)

# Хараат бус аудиторын дүгнэлт

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

### *Дүгнэлт*

Бид “ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК-ийн (цаашид “ББСБ” гэх)-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх баланс, уг өдрөөр дуусгавар болсон орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “Очир Ундраа ОМЗ ББСБ” ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаархи баланс, уг өдрөөр дуусгавар болсон орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тэдгээрийн нэмэлт тодруулгууд нь материаллаг байдлын хувьд Санхүүгийн зохицуулах хорооны баталсан зааврын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### *Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм-ийг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба НБЭЗОУСЗ-ийн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

### *Аудитын Гол Асуудлууд*

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Компани Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 147 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах үүрэгтэй ба дээрх журмын 3.3.6 ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй байна. Энэхүү асуудалтай холбоотойгоор бид дүгнэлтээ хязгаарлаагүй болно.

*Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага*

Удирдлага нь СТОУС болон Монгол улсад мөрдөгдөж буй НББ-ийн үндсэн зарчмуудад нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан заавар, журмын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгох зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

*Санхүүгийн Тайлагналын Аудитад хүлээн Аудиторын Үүрэг Хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталсан ажилладаг.

Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтааад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл харуул хамгаалалт

зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

*Тайлангийн хэрэглээ*

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд болон зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад зориулан гаргасан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

ХҮНДЭТГЭСЭН,  
  
Б.ОСОРГАРАВ  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Улаанбаатар хот, Монгол улс  
2017 оны 02 дугаар сарын 03

## Баланс

Үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
<b>Хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	3	861,897	1,377,038
Зээл урьдчилгаа (цэврээр)	4	12,283,749	13,253,131
Бусад хөрөнгө	5	202,182	269,571
Үндсэн хөрөнгө /цэврээр/	6	732,151	742,383
Биет бус хөрөнгө		-	3,900
<b>Нийт хөрөнгийн дүн</b>		<b>14,079,979</b>	<b>15,646,023</b>
<b>Өр төлбөр</b>			
Бусад эх үүсвэрийн өглөг	7	3,452,093	2,500,356
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	8	264,494	155,406
Бусад өглөг	9	54,784	86,357
Урт хугацаат өр төлбөр	10	809,000	891,075
<b>Өр төлбөрийн дүн</b>		<b>4,580,371</b>	<b>3,633,194</b>
<b>Өөрийн хөрөнгө</b>			
Хувьцаат капитал	11	2,500,000	2,500,000
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг		684,000	684,000
Хуримтлагдсан ашиг	12	6,315,608	8,784,232
Нийгмийн хөгжлийн сан		-	44,597
<b>Өөрийн хөрөнгийн дүн</b>		<b>9,499,608</b>	<b>12,012,829</b>
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>		<b>14,079,979</b>	<b>15,646,023</b>



Уг санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр батлав:

Б.Цогтгэрэл  
Гүйцэтгэх захирал

Г.Болортуяа  
Нягтлан бодогч

Энэхүү санхүүгийн тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 7 -оос 24 дүгээр хуудсан дах санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.